4.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.5.4.</b> Санхүүгийн баримтын шалгалтад хамрагдсан хуулийн этгээд	тоо	44	9	9	<b>26</b>	<b>30</b>	
5.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.5.5.</b> Баримтын шалгалтаар илэрсэн зөрчил	сая төгрөг	196,930.2	10,000.0	40,900.0	<b>20,000.0</b>	<b>49,735.68</b>	
6.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.5.6.</b> Зөрчил арилгуулахаар авсан арга хэмжээний хэрэгжилт	хувь	100	59.4	62.1	<b>100</b>	<b>134.6</b>	
7.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.5.7.</b> Зөвлөмж, цаашид авах арга хэмжээ	тоо	187	75	80	<b>150</b>	<b>202</b>	

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨБХХ

### ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

**Гүйцэтгэлийн зорилт № 1.6.** Худалдан авах ажиллагааны талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг туршлага, худалдан авах ажиллагааны хөгжлийн чиг хандлагыг судлан нэвтрүүлэх

№ 13 (13)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.6.1-р арга хэмжээ</b>					
	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал боловсруулах					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 3.1, ЗГҮАХХАХТ-ний 5.2.2.1, ЭЗНХҮЧ-ийн 18.4 дахь зорилт, арга хэмжээ, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 12 дахь хэсэг.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	2,500.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	Худалдан авах ажиллагааны хэлтэс (Цаашид "ХААХ" гэх), Мэдээлэл, технологийн алба (Цаашид "МТА" гэх), ЗХЗХ				
	Суурь түвшин	Хуулийн зарим зохицуулалт өнөөгийн шаардлага хангахгүй байгаагаас зохицуулалтыг тодорхой болгох шаардлага үүссэн.				

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал боловсруулсан эсэх; - Саналыг Сангийн яаманд хүргүүлсэн эсэх.
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> - Хуулийн төсөлд тусгах санал боловсруулсан байх; - Саналыг холбогдох байгууллага, оролцогчдоос авах ажлыг зохион байгуулсан байх; - Сангийн яаманд хуулийн төсөлд тусгах саналыг хүргүүлсэн байх. <b>Жилийн эцэст:</b> - Хуулийн төсөл батлагдаж, хэрэгжих боломжтой болсон байна.
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	<i>Хэрэгжилт</i>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг Сангийн яаманд байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл оролцож ажилласан болно. Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос эрхлэн 2 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын удирдлага, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Мэдээлэл, технологийн албаны дарга, мэргэжилтнүүд оролцож, санал, мэдээлэл солилцов. Мөн 3 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд УИХ-ын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаан, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Газрын дарга асан Б.Ганбат, Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу нар оролцон мэдээлэл, танилцуулга хийв. УИХ-ын ээлжит бус чуулганы 3 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн шатны хэлэлцүүлэг хийгдэж, батлагдсан. Нэмэлт өөрчлөлт оруулсан хууль 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Сангийн яамтай хамтран зохион байгуулсан Засгийн газрын 2018 оны худалдан авах ажиллагааны тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт танилцуулах ажил хэргийн семинарын үеэр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны цахим системийн хэрэглээ, цаашдын хөгжил, хандлагыг танилцуулав.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	2,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиг үүргийг бие даасан агентлаг байгуулан хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газар байгуулахтай холбогдуулан Засгийн газрын агентлаг байгуулах тухай тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 438 дугаар тогтоолоор батлуулсан. Үүнтэй холбогдуулан Төрийн худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн саналыг 2019 оны 12 дугаар сарын 24-ний А-1/4358 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>	100 %, “Бүрэн хэрэгжсэн”	

<b>№ 14 (14)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.6.2-р арга хэмжээ</b> Худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, жишиг баримт бичгийг шинэчлэх төсөл боловсруулж, саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Стратегийн зорилт 3.1, ЗГҮАХХАХТ-ний 5.2.2.1, 5.2.2.2, ЭЗНХҮЧ-ийн 18.4 дахь зорилт, арга хэмжээ, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 12 дахь хэсэг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.4., 4.1.4.2,				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	1,700.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	МТА				
	<i>Суурь түвшин</i>	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн. - Хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой гарах журам, заавар: – Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам байхгүй байсан.				

		<p>– Тендерт шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам байхгүй байсан.</p> <p>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам батлагдсан.</p> <p>- Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал батлагдсан.</p>
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<p>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан эсэх;</p> <p>- Холбогдох журам батлагдсан эсэх.</p>
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <p>- ТБОНӨХБАҮХАТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэг хийх, батлагдсан байх;</p> <p>- Дараах 5 журмын төсөлд тусгах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байх:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам;</li> <li>2. Тендерт шалгаруулалтын материалын тухайн тендерт оролцогчдод ил болгох журам;</li> <li>3. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх журам;</li> <li>4. Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам;</li> <li>5. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам.</li> </ol> <p><b>Жилийн эцэст:</b> Хууль, журмын төсөл батлагдаж, мөрдүүлж эхэлсэн байх.</p>
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	<i>Хэрэгжилт</i>	<p>“Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, “Тендерт шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох, журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэгт Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу ажиллаж, ажлын хэсгээс журмын төслийг боловсруулан, батлуулсан. Эдгээр хуулийн төсөлд саналаа хүргүүлж, Сангийн яаманд байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон ажилласан ТӨБЗГ-ын төлөөллөөр дамжуулан байгууллагын байр суурь, саналыг тусгуулсан. Мөн “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-ын төсөлд тусгах санал боловсруулж, 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А-1/245, “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын төсөлд 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А-1/1290 дугаар албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>“Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын төслийг Мэдээллийн технологийн албанаас боловсруулж, ажлын хэсэгт танилцуулан, Сангийн сайдаар батлуулав.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	1,700.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан.</p> <p>Шинээр дараах 6 журам батлагдсан:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар);</li> <li>2. “Тендерт шалгаруулалтын материалын тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” (Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар);</li> <li>3. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор);</li> <li>4. “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор);</li> <li>5. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар);</li> <li>6. “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” (Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалаар).</li> </ol>
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>	100 %, “Бүрэн хэрэгжсэн”	

**Гүйцэтгэлийн зорилт № 1.6.-ын үр дүн:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйг боловсронгуй болгоход чиглэсэн хууль тогтоомжийн төсөлд санал боловсруулж, тусгуулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд	Жилийн эцэст		Жилийн эцэст	
					Төл.	Гүй.	Төл.	Гүй.

1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.6.1.</b> Санал боловсруулж, тусгасан хуулийн төсөл	тоо	1	1	1	1	1
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.6.2.</b> Боловсруулсан саналыг тусгасан журам, зааврын тоо	тоо	2	3	3	5	6
3.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.6.3.</b> Баталж, мөрдүүлсэн журам, зааврын тоо	тоо	2	3	3	5	6

Мэдээллийн эх сурвалж: Сангийн яам, ТӨБЗГ-ын МТА

#### ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 4: ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ

**Гүйцэтгэлийн зорилт № 1.7.** Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дэд системүүдийг хэрэглээг сайжруулж, ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг “Цахим дэлгүүр”-ээр дамжуулан зохион байгуулан төсвийн урсгал зардлын хэмнэлт бий болгох

№ 15 (15)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1-р арга хэмжээ</b> “Цахим дэлгүүр”, “Цахим каталог”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 3.3, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.17 (тоон гарын үсэг, цахим засаг), 5.2.2.1, 5.2.2.2, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.9 дахь зорилт, арга хэмжээ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.4.1 зорилт.				
үйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	1,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	МТА				
	Суурь түвшин	“Цахим дэлгүүрийн систем”-ийг 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр ашиглалтад оруулсан. 2018 оны үзүүлэлт: - Нэр төрлийн тоо – 18; - Захиалагчийн тоо – 40; - Нийлүүлэгчийн тоо – 10; - Гэрээний тоо – 40; - Нийт захиалга - 3,733,408,890.0 төгрөг; - Төсвийн хэмнэлт - 518,087,177.0 төгрөг.				
	Шалгуур үзүүлэлт	Захиалагчийн тоо, нийлүүлэгчийн тоо, нийт захиалгын тоо, хэмнэлтийн дүнгийн өсөлт, “Цахим дэлгүүр”-ээр нийлүүлэх бараа, ажил, үйлчилгээний “Цахим каталог”-ийн тоо хэмжээ, захиалагч, нийлүүлэгч байгууллагуудыг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан байдал, тоогоор, чанараар.				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Шалгуур үзүүлэлтийн тоо хэмжээ төрөл бүр дээр 10< хувиар өссөн байна. <b>Жилийн эцэст:</b> Шалгуур үзүүлэлтийн тоо хэмжээ төрөл бүр дээр 20< хувиар өссөн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>“Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Энэ хүрээнд 31 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 15 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр ерөнхий гэрээний худалдан авалтыг амжилттай гүйцэтгэв.</p> <p>Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Элэгний В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурыг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг амжилттай зохион байгуулж, 2019 оны 03 сарын 22-ны өдөр шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулж, 2 дахь шатны сонгон шалгаруулалтыг “Цахим дэлгүүр”-ийн системээр гүйцэтгэсэн.</p> <p>2019 онд зохион байгуулсан ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд “Цахим дэлгүүр”-ээр нийт 2223 удаагийн захиалга хийгдэн 31 нэр төрлийн 8.9 тэрбум төгрөгийн эм, хэрэгсэл худалдан борлуулагдаж, улсын төсвийн урсгал зардалд 464.9 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ний бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 27085 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 3234-өөр (23851 байсан) буюу 13.6 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд ХХААХҮЯ-тай хамтран “Монголд үйлдвэрлэв” 2017, 2018 оны дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний</p>				

		каталогийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -ийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, нийлүүлэгчдэд сурталчлан танилцуулав. “Цахим дэлгүүр”-ийн системийн хэвийн тасралтгүй байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж, захиалагч болон нийлүүлэгч талуудыг системийн хэрэглээний зааварчилга, зөвлөмжөөр хангаж ажилласан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	1,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Барааны нэр төрлийн тоо хэмжээ - 31 төрлийн эм;</li> <li>- Захиалагчийн тоо – эрүүл мэндийн 270 байгууллага;</li> <li>- Нийлүүлэгчийн тоо – ерөнхий гэрээ байгуулсан 15 эм хангах ААН;</li> <li>- Ерөнхий гэрээний тоо – 47;</li> <li>- Захиалгын дүн - 8,961,344,342.0 төгрөг;</li> <li>- Хэмнэлт - 464,888,248.0 төгрөг.</li> </ul> <p>Цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ний бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 27085 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 3234-өөр (23851 байсан) буюу 13.6 хувиар нэмэгдсэн байна.</p>
	<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 %, “Бүрэн хэрэгжсэн”

№ 16 (16)	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.2-р арга хэмжээ</b> 2019 онд Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Стратегийн зорилт 3.3, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.17 (тоон гарын үсэг, цахим засаг), 5.2.2.1, 5.2.2.2, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.9 дахь зорилт, арга хэмжээ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.4.1 зорилт.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	МТА				
	<i>Суурь түвшин</i>	Эрүүл мэндийн яамны судалгаанд үндэслэн 18 нэр төрлийн эмийг сонгож, “Зарим ерөнхий нэршлийн эмийг худалдан авах Ерөнхий гэрээ байгуулах” тендер шалгаруулалт зохион байгуулсан. 2018 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр 10 нийлүүлэгч байгууллагатай нэр төрөл давхардсан тоогоор 40 ерөнхий гэрээ байгуулж, “Цахим дэлгүүр”-ийн системд байршуулсан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Тендер шалгаруулалт зохион байгуулсан эсэх, Ерөнхий гэрээ байгуулсан тоо, Нийлүүлэгч, захиалагчийн тоо, Ерөнхий гэрээний хэрэгжилтийн дүн мэдээ, хувиар.				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b> 2019 онд ерөнхий гэрээ байгуулсны дүнд “Цахим дэлгүүр”-ээс худалдан авах барааны шалгуур үзүүлэлтийн тоо мэдээ тус бүр 10&lt; хувиар өссөн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> 2019 онд ерөнхий гэрээ байгуулсны дүнд “Цахим дэлгүүр”-ээс худалдан авах барааны шалгуур үзүүлэлтийн тоо мэдээ тус бүр 20&lt; хувиар өссөн байна.</p>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалт”-д тусгагдсан “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Энэ хүрээнд 31 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 15 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр ерөнхий гэрээний худалдан авалтыг амжилттай гүйцэтгэв.</p> <p>Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Элэгний В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурыг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг амжилттай зохион байгуулсны дүнд 2019 оны 03 сарын 22-ны өдөр шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулж, 2 дахь шатны сонгон шалгаруулалтыг “Цахим дэлгүүр”-ийн дэд системээр гүйцэтгэж байна.</p> <p>Улсын хэмжээнд тус цахим системээр эрүүл мэндийн салбарын 270 захиалагч байгууллагын 2223 удаагийн 8,961,344,342.0 төгрөгийн захиалгаар 28,797,866 тооны 31 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулагдсан байна. Үүний дүнд улсын төсвийн урсгал зардалд 464.9 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p>				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв				
	<i>Хүрсэн түвшин</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Барааны нэр төрлийн тоо хэмжээ - 31 төрлийн эм;</li> <li>- Захиалагчийн тоо – эрүүл мэндийн 270 байгууллага;</li> <li>- Нийлүүлэгчийн тоо – ерөнхий гэрээ байгуулсан 15 эм хангах ААН;</li> </ul>				

		<ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий гэрээний тоо – 47;</li> <li>- Захиалгын дүн - 8,961,344,342.0 төгрөг;</li> <li>- Хэмнэлт - 464,888,248.0 төгрөг.</li> </ul> <p>Ерөнхий гэрээний энэхүү худалдан авалтын хүрээнд 10 (31.3%) нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч, эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийг хийж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн байна.</p>
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

**Гүйцэтгэлийн зорилт № 1.7.-ын үр дүн:** “Цахим дэлгүүр”, “Цахим каталоги” дэд системийн хэрэглээ нэмэгдэж, системийн холбогдох үзүүлэлтүүд дунджаар 20 хувиар өссөн байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.1.</b> “Цахим каталоги” дэд систем дэх бараа, ажил, үйлчилгээ	тоо	23851	25000	26659	27000	27085
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.2.</b> “Цахим дэлгүүр”, “Цахим каталоги” дэд системийн талаар хэрэглэгч захиалагч, нийлүүлэгчид өгсөн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг	тоо	3	5	6	7	10
		Хамрагдсан хүний тоо	150	165	250	180	1127
3.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.3.</b> Ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалт	тоо	1	2	3	2	2
4.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.4.</b> Ерөнхий гэрээгээр нийлүүлэх барааны нэр төрлийн хэмжээ	тоо	18	20	29	25	32
5.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.5.</b> Ерөнхий гэрээ байгуулсан байдал	тоо	40	44	45	48	48
6.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.6.</b> Ерөнхий гэрээний худалдан авалтын захиалагч	тоо	40	44	45	48	48
7.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.7.</b> Ерөнхий гэрээний худалдан авалтын нийлүүлэгч	тоо	10	11	15	12	12
8.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.8.</b> Ерөнхий гэрээний худалдан авалтын захиалгын дүн	тоо	432	1111	712	2223	2223
		төгрөг	3,733,408,890	4,106,749,779	3,885,951,068	4,480,090,668	8,961,344,342
9.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 1.7.9.</b> Ерөнхий гэрээний худалдан авалтын дүнд бий болсон улсын төсвийн хэмнэлтийн дүн	төгрөг	518,087,177.0	569,895,894.0	165,199,796.0	621,704,612.0	464,888,248.0

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем



**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Үйлчилгээний төрөл	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь
1.	Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ (давхардсан тоогоор)	5	14	92.9 %
2.	Мэргэжилтэй ажилтанд зориулсан үйлчилгээ (давхардсан тоогоор)	7	14	97.9 %
3.	Иргэнд чиглэсэн үйлчилгээ (давхардсан тоогоор)	4	12	94.2 %
<b>Нийт (давхардсан тоогоор)</b>		<b>16</b>	<b>40</b>	<b>95.0 %</b>

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь
1.	<a href="#">Үндсэн чиг үүрэг №1.</a> Төрийн өмчийн удирдлага, менежмент	1	3	100.0 %
2.	<a href="#">Үндсэн чиг үүрэг №2.</a> Төрийн өмчийн бүртгэл, хяналт	2	2	85.0 %
3.	<a href="#">Үндсэн чиг үүрэг №3.</a> Засгийн газрын худалдан авах ажиллагаа	2	6	95.0 %
4.	<a href="#">Үндсэн чиг үүрэг №4.</a> Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем	2	8	91.3 %
5.	<a href="#">Үндсэн чиг үүрэг №5.</a> Төрийн захиргааны удирдлага	1	4	100.0 %
<b>Нийт</b>		<b>8</b>	<b>23</b>	<b>94.3 %</b>

# ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, МЕНЕЖМЕНТ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.1.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд) чиглэсэн.

№ 01 (17)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1-р арга хэмжээ</b>					
	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, гэрээг сунгах эсэх шийдвэрийг газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэх					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 1.2, ЗГҮАХХАХТ-ний 5.2.1.2, ЭЗНХҮЧ-ийн 18.4-р арга хэмжээ				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	10,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	БТУХ				
	Суурь түвшин	-				
	Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>- 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн эсэх.</li> <li>- Гэрээ сунгах эсэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлсэн байх.</li> <li>- Холбогдох хууль, журамд нийцсэн байх.</li> </ul>				
Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b>					
	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулсан байна.</li> <li>- 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, захирлуудын контрактын биелэлтийг дүгнэж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн байна.</li> <li>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд захирлуудын контрактыг сунгах эсэх асуудлыг хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсан байна.</li> </ul>					
	<b>Жилийн эцэст:</b>					
	<ul style="list-style-type: none"> <li>- Контрактыг дүгнэсэн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</li> <li>- Захирлуудын 2019 оны контрактыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</li> </ul>					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар байгуулагдсан төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контракт, 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлаар нийт 44 хуулийн этгээдийн захиралтай байгуулсан контрактыг хэлэлцэж дүгнэсэн. Уг ажлын хэсгийн дүн, дүгнэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанд танилцуулан контрактыг сунгах эсэх асуудлаар шийдвэр гаргуулсан. Хуралдааны шийдвэрээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу ТӨҮГ, төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагатай контракт байгуулах ажлыг зохион байгуулсан.				
	Зарцуулсан хөрөнгө	10,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв				
	Хүрсэн түвшин	Төрийн өмчит нийт 21 үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулсан. Төрийн өмчит 24 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд гүйцэтгэх захиралтай байгуулах контрактыг 1 жилээр байгуулах тухай удирдамж, чиглэл өгөв.				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100 %, “Бүрэн хэрэгжсэн”				

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд) чиглэсэн.



№ 02 (18)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.2-р арга хэмжээ</b>					
	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газрын хуралдаанд танилцуулах, шийдвэрлүүлэх					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 1.2, ЗГҮАХХАХТ-ний 5.2.1.2, ЭЗНХҮЧ-ийн 18.4-р арга хэмжээ				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	10,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	БТУХ				
	Суурь түвшин	- 43 хуулийн этгээдийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан.				
	Шалгуур үзүүлэлт	- 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангасан байна. - Холбогдох хууль, журамд нийцсэн байна.				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, ажиллуулсан байна. - 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргасан байна. - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна.  <b>Жилийн эцэст:</b> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 43 хуулийн этгээдийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжиж, эдийн засгийн үр өгөөж нэмэгдсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 25 компани, 18 төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан.				
	Зарцуулсан хөрөнгө	10,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв				
	Хүрсэн түвшин	Нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 6,960.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 5,129.0 тэрбум төгрөгийн зардал гарган 1,346.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"				

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд) чиглэсэн.

№ 03 (19)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.3-р арга хэмжээ</b>					
	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газрын хуралдаанд танилцуулах, шийдвэрлүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 1.2, ЗГҮАХХАХТ-ний 5.2.1.2, ЭЗНХҮЧ-ийн 18.4-р арга хэмжээ				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	2,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	БТУХ				
	Суурь түвшин	- 43 хуулийн этгээдийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан.				
	Шалгуур үзүүлэлт	- 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан эсэх; - Холбогдох хууль, журамд нийцсэн байх.				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - <b>Жилийн эцэст:</b> - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар ажлын хэсэг				

		байгуулж, ажиллуулсан байна. - 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргасан байна. - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 46 хуулийн этгээдийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталж, оны эхнээс хэрэгжих боломжтой болсон байна.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Газрын даргын 2019 оны А/281 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 25 компани, 20 төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянан санал, дүгнэлт гаргаж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.
	Зарцуулсан хөрөнгө	2,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв
	Хүрсэн түвшин	Төрийн өмчит 45 хуулийн этгээдийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан. "Төрийн орон сууцны корпорац" ХХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах асуудал хүлээгдэж байгаа.
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

**Гүйцэтгэлийн зорилт № 2.1.-ийн үр дүн:** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, өмчийн үр өгөөж нэмэгдсэн байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин Өмнөх улирал	Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт №2.1.1.</b> Алдагдалтай ажилласан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо	тоо	32	46 Үүнээс: Эрчим хүчний компани 13	51 Үүнээс: Эрчим хүчний компани 10	18 Үүнээс: Эрчим хүчний компани 13	20 Үүнээс: Эрчим хүчний компани 17
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт №2.1.2.</b> Ашигтай ажилласан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо	тоо	51	29 Үүнээс: Эрчим хүчний компани 9	24 Үүнээс: Эрчим хүчний компани 15	57 Үүнээс: Эрчим хүчний компани 11	57 Үүнээс: Эрчим хүчний компани 8
3.	<b>Үр дүнгийн үзүүлэлт №2.1.3.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт цэвэр ашиг	Тэрбум төгрөг	1,290.5	999.4	999.4	1,346.8	1,346.8

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын БТУХ

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.2.** Төрийн өмчийн ашиглалтад бүртгэлээр хяналт тавьж, өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг бууруулах

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд) чиглэсэн.

№ 04 (20)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1-р арга хэмжээ</b>					
	Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоох асуудлыг Газрын хуралдаанд танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах					
	Төлөвлөлтийн уялдаа:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.1, ЗГҮАХХАХТ-ний 5.2.1.7, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоол.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	6,400.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ТӨБХХ				
	Суурь түвшин	- Төрийн өмчит 1052 хуулийн этгээдийн 6020 автомашины тоо, төрөл болон зардлын судалгааг 2018 оны санхүүгийн жилээр гаргасан.				
	Шалгуур үзүүлэлт	- Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрөл; - Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга боловсруулсан байх.				

	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Төрийн өмчит 1052 хуулийн этгээдийн 6560 автомашины зардлын судалгаа, мэдээллийг нэгтгэсэн байх. <b>Жилийн эцэст:</b> Төрийн өмчит 1052 хуулийн этгээдийн автомашины зардлын судалгаа, мэдээллийг нэгтгэж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байх.
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	<i>Хэрэгжилт</i>	Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 онд төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины судалгаа, зардлын судалгааг авч нэгтгэн дээд шатны байгууллагад саналаа боловсруулж хүргүүлсэн. Шийдвэр гараагүй. ЗГХЭГ-аас автомашины тоо төрөл болон зардлын судалгааг шинэчлэн тогтоох чиглэл өгсний дагуу 1052 хуулийн этгээдийн 6560 автомашины холбогдох мэдээлэл, зардлын судалгааг хүлээн авч дүнг нэгтгэсэн. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх, байгуулах ажлын хүрээнд нийслэл, 21 аймагт бүртгэлийн мэргэжилтнүүд 11 дүгээр сард ажиллах ажлын удирдамжид төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины газар дээр нь үзэн тоолж, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран тээврийн хэрэгслийн гэрчилгээний арлын дугаартай таарч байгаа эсэхийг шалган тулган баталгаажуулав. Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины холбогдох зардлын судалгааг нягталж, нэгтгэх ажлыг зохион байгуулсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	6,400.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины судалгаа, мэдээллийг нэгтгэсэн. ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		70 %, “Хэрэгжих шатанд”

**Гүйцэтгэлийн зорилт № 2.2.-ын үр дүн:** Төрийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлж, төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэст		
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.	
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.2.1</b> Автомашины судалгаанд хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээд	тоо	1052	-	-	<b>1052</b>	<b>1052</b>	
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.2.2</b> Автомашины талаар авах арга хэмжээний төсөл боловсруулах	Чанар:	-	-	-	<b>Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах</b>	<b>Үгүй, (ТӨБЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлээгүй байна.)</b>	

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨБХХ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.3.** Орон нутгийн өмчийн байгууллагын албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Нийслэл, орон нутгийн өмчийн байгууллагын албан хаагчдад) чиглэсэн.

<b>№ 05 (21)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1-р арга хэмжээ</b> Орон нутгийн нэгжийн мэргэжилтнүүдэд сургалт, семинар зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.5.1, 53.5.5 дахь заалт, Стратегийн зорилт 1.4, 2.4.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	3,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ТӨБХХ, ЗХЗХ, ХААХ, МТА, БТУХ				
	<i>Суурь түвшин</i>	- 2018 онд нийслэл, орон нутгийн өмчийн 22 байгууллагын давхардсан тоогоор 2000 албан хаагчид өмчийн болон худалдан авах ажиллагааны чиглэлээр нэгдсэн болон орон нутаг дахь сургалтыг 45 удаа зохион байгуулж, чадавхийг дээшлүүлсэн.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	- Сургалтын тоо; - Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо; - Сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулсан байх.				

	<p><i>Хүрэх түвшин</i></p>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 4 дүгээр сард урьдчилан баталсан хөтөлбөрийн дагуу ТӨБЗГ-т нэгдсэн сургалт зохион байгуулсан байна;</li> <li>- Зохион байгуулсан сургалтын тоо – 1,</li> <li>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо (давхардсан тоогоор) - 88;</li> <li>- Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 25 удаа.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 4 болон 10 дугаар сард урьдчилан баталсан хөтөлбөрийн дагуу ТӨБЗГ-т болон нийслэл, 21 аймагт сургалт зохион байгуулсан байна;</li> <li>- Зохион байгуулсан сургалтын тоо – 50,</li> <li>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо (давхардсан тоогоор) – 2100;</li> <li>- Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 50 удаа.</li> </ul>
<p><b>Арга хэмжээний хэрэгжилт</b></p>	<p><i>Хэрэгжилт</i></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэл, 21 аймаг дахь үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэгтгэлийг хянан хүлээн авах ажлыг зохион байгуулж, нэгдсэн цугларалт, сургалтыг Газрын даргын 2019 оны А/110 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 4 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд зохион байгуулсан.</li> <li>21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийт 88 албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ТӨБЗГ-ын бүртгэлийн мэргэжилтнүүд хуваарийн дагуу аймгийн төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой мэдээ, тайланг хүлээн авсан.</li> <li>ТӨБЗГ-ын даргын А/110 дугаар тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу 04 дүгээр сарын 24-ний өдөр нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт семинар зохион байгуулав.</li> <li>2. 2019 оны 11 дүгээр сард өмчийн бүртгэлийн мэргэжилтнүүд нийслэл, 21 аймагт ажиллаж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны биелэлтийг дүгнэж, 2019 оны гэрээ байгуулах ажлын удирдамжын хүрээнд давхардсан тоогоор нийт 50 удаа сургалт семинар хийж, орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн 1438 албан хаагчид өмчийн харилцааны талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, анхаарах асуудлын талаар семинар, сургалт зохион байгуулсан.</li> <li>3. Өмчийн харилцааны асуудлаар шаардлагатай байгууллагын албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг, туслалцааг нийт 50 удаа өгч ажиллав.</li> <li>4. МТАлбанаас дор дурдсан сургалт семинар, арга зүйн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллав: <ul style="list-style-type: none"> <li>- 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ОБЕГ-ын хүсэлтээр тус байгууллагын харьяа байгууллагуудын нягтлан бодогч, ерөнхий санхүүчдэд “Төрийн болон Орон нутгийн Өмчийн Удирдлагыг Мэдээлэлжүүлэх Систем”, “Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн ашиглалтын талаар;</li> <li>- 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн худалдан авах ажиллагааны газартай хамтран Дүүргийн нэгжүүдэд “Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн ашиглалтын талаар;</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан 21 аймаг, Нийслэлийн худалдан авах ажиллагааны нэгж, 9 дүүргийн худалдан авах ажиллагааны нэгжийн албан хаагчдын төлөөллийг хамруулсан сургалтыг Сангийн яамтай хамтран;</li> <li>- “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-тэй холбоотой асуудлаар нийт 1129 байгууллагад зөвлөгөө, тусламж, дэмжлэг үзүүлэн ажилласан;</li> <li>- 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Орон нутгийн өмчийн газруудын зөвлөгөөнд оролцсон албан хаагчдад “Худалдан авах ажиллагааны цахим систем”, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн ашиглалтын талаар;</li> <li>- Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр Цахим худалдан авах ажиллагааны системийн болон Ерөнхий гэрээг хэрэгжүүлж буй “Цахим дэлгүүр”-ийн системийн сургалтыг Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий, Увс, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Ховд аймгийн 200 орчим захиалагч болон нийлүүлэгч байгууллагын 620 албан хаагчдыг хамруулсан сургалтыг орон нутагт 9 дүгээр сарын 9-27-ны өдрийн хооронд;</li> <li>- Мөн Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр Цахим худалдан авах ажиллагааны системийн болон Ерөнхий гэрээг хэрэгжүүлж буй “Цахим дэлгүүр”-ийн системийн сургалтыг Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын болон тендэрт оролцогч аж ахуй нэгжүүдийн төлөөлөл бүхий 200 орчим байгууллагын 300 албан хаагчийг хамруулсан сургалтыг орон нутагт 10 дугаар сарын 21-25-ны хооронд Сангийн яамтай хамтран;</li> <li>- Дэлхийн банкны Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүжилтээр Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг 11-р сарын 12-15-</li> </ul> </li> </ol>

		ны өдрүүдэд Архангай аймагт (38 суралцагч), 11-р сарын 13-15-ны өдрүүдэд Завхан аймагт (66 суралцагч), 11-р сарын 12-17-ны өдрүүдэд Орхон аймагт (68 суралцагч), 11-р сарын 06-08-ны өдрүүдэд (60 суралцагч), 11-р сарын 04-07-ны өдрүүдэд Хэнтий аймагт (60 суралцагч), 11-р сарын 03-06-ны өдрүүдэд Өмнөговь аймагт (50 суралцагч), 11-р сарын 01-03-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт (22 суралцагч), Булган аймагт (35 суралцагч) тус тус зохион байгуулж, нийт 399 албан хаагч, иргэнийг хамруулсан байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	3,500.0 мянган төгрөгийг ТӨБЗГ-ын төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	2019 онд нийслэл, орон нутгийн өмчийн 22 байгууллагын давхардсан тоогоор 2100 албан хаагчдад өмчийн болон худалдан авах ажиллагааны чиглэлээр нэгдсэн болон орон нутаг дахь сургалтыг 50 удаа зохион байгуулж, чадавхийг дээшлүүлсэн. Өмчийн харилцааны асуудлаар нийт 50 удаа мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгсөн байна. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн албан хаагчийг бэлтгэх болон худалдан авах ажиллагаа, өмчийн цахим системийн чадавхийг сайжруулах сургалтыг давхардсан тоогоор нийт 162 удаа зохион байгуулж, 3000 хүнийг хамруулан чадавхижуулсан байна. Өмчийн бүртгэлийн цахим системийн ашиглалттай холбоотой нийт 1129 байгууллагад зөвлөгөө өгч, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

**Гүйцэтгэлийн зорилт № 2.3.-ын үр дүн:** Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих чадавх сайжирна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.1</b> Өмчийн асуудлаар зохион байгуулсан сургалт (давхардсан тоогоор)	тоо	45	1, ХАА, цахим 45	1, ХАА, цахим 50	50, ХАА, цахим 45	51, ХАА, цахим 162
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.2</b> Өмчийн асуудлаар зохион байгуулсан сургалтад хамрагдсан албан хаагчид (давхардсан тоогоор)	тоо	2000	88, ХАА, цахим 1320	88, ХАА, цахим 1890	2100	1526, ХАА, цахим 3000
3.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.3</b> Төрийн өмчийн харилцааны асуудлаар зөвлөгөө, мэргэжил, арга зүйгээр хангасан байдал	тоо	42	25	25, Цахим системийн талаар 445	50	50, цахим системийн талаар 1129
4.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.4</b> Худалдан авах ажиллагаа, цахим системийн ашиглалттай холбоотой зохион байгуулсан сургалт	тоо	5	10	48	15	98
5.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.5</b> Худалдан авах ажиллагаа, цахим системийн ашиглалттай холбоотой зохион байгуулсан сургалтад хамрагдалт	Хүний тоо	193	212	290	231	1440

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨБХХ, МТА

### ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

**Гүйцэтгэлийн зорилт № 2.4.** Засгийн газрын худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах сургалт, семинар зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжилтэй ажилтанд чиглэсэн үйлчилгээ

<i>№ 06 (22)</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>	
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.1-р арга хэмжээ</b> Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулах	
	<i>Төлөвлөлтийн</i>	Стратегийн зорилт 3.5,

		уялдаа:				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	1,300.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ХААХ, МТА				
	Суурь түвшин	<ul style="list-style-type: none"> <li>- Нийт АЗ эзэмшигчийн нийт тоо – 12963;</li> <li>- Тайлант хугацаанд АЗ гэрчилгээ шинээр эзэмшигчийн тоо – 4103;</li> <li>- Сургалтад хамрагдагсдын тоо – 7081;</li> <li>- Шалгалтын тоо – 408;</li> <li>- Цахим сургалтын систем ашиглалтад ороогүй байсан.</li> </ul>				
	Шалгуур үзүүлэлт	Дэлхийн банкны санхүүжилтээр Сангийн яам, ТББ-тай хамтран сургалт зохион байгуулах; Сургалтад хамрагдагсдын тоо; АЗ гэрчилгээ шинээр эзэмшигчийн тоо; Онлайн болон бусад хэлбэрээр шалгалт авч, гэрчилгээ (АЗ) олгох.				
	Хүрэх түвшин	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дэлхийн банкны санхүүжилтээр Сангийн яам, ТББ-тай хамтран худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулж, шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.</li> <li>- Хэрэгжилт 50 хувь.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургалтад нийслэл, 21 аймгийн 7000 хүнийг хамруулсан байна;</li> <li>- Цахим хэлбэрээр шалгалт авч, гэрчилгээ (АЗ) олгох нөхцөл бүрдсэн байна;</li> <li>- Хэрэгжилт 100 хувь.</li> </ul>				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим сургалтад нийт 215 суралцагч хамрагдсан байна.</li> <li>- Дэлхийн банкны санхүүжилтээр худалдан авах ажиллагааны сургалт явуулах эрх бүхий ТББ-тай хамтран 2019 онд 21 аймаг, нийслэл, дүүрэг, төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2 удаа буюу 5-6 сар 10-11 сард зохион байгуулсан. Тус сургалтад нийт 1004 хүн хамрагдаж, 571 хүн АЗ гэрчилгээ эзэмшигч болсон.</li> <li>- АЗ гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд цахим сургалтын дэд систем <a href="http://surgalt.tender.gov.mn">http://surgalt.tender.gov.mn</a> -ээр сургалтад хамрагдаж, шалгалт өгөх боломжийг бүрдүүлсэн.</li> <li>- Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтыг эрх бүхий сургалтын байгууллагаас нийт 406 удаа зохион байгуулж, түүнд 9046 суралцагч шалгалтад хамрагдсанаас 5352 суралцагч тэнцэж, гэрчилгээ эзэмшигч болсон. Гэрчилгээ шинээр эзэмшигчийн бүртгэл мэдээллийг цахим системд бүртгэх ажлыг гүйцэтгэв.</li> </ul>				
	Зарцуулсан хөрөнгө	1,300.0 мянган төгрөгийг ТӨБЗГ-ын төсвийн эх үүсвэрээр.				
	Хүрсэн түвшин	<ol style="list-style-type: none"> <li>1. Дэлхийн банкны санхүүжилт “Тогтвортой амьжилгаа 3” төслийн хүрээнд: Сургалтад нийт хамрагдсан хүн – 1004; АЗ эзэмшигчийн тоо – 571; Цахим сургалтын систем <a href="http://surgalt.tender.gov.mn">http://surgalt.tender.gov.mn</a> ашиглалтад орсон.</li> <li>2. Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ олгох сургалт – 406, хамрагдалт 9046, шинээр гэрчилгээ эзэмшигч 5352.</li> </ol>				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”				

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжилтэй ажилтанд чиглэсэн үйлчилгээ

№ 07 (23)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.2-р арга хэмжээ</b>					
	Захиалагч болон тендерт оролцогчдод худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 3.4,				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	10,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ХААХ				
	Суурь түвшин	Хэрэгжилт 100 хувь.				
	Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөх, шалган туслах ажлыг хийсэн байна.</li> <li>- Хэрэгжилт 100 хувь</li> </ul>				
	Хүрэх түвшин	<p><b>Эхний хагас жилд:</b> Хэрэгжилт 50 хувь.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө мэдээлэл өгч, мэргэжил арга зүйгээр хангах, шалган туслах ажлын зохион байгуулсан байна.</li> </ul>				

		- Орон нутагт хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны чанар дээшилнэ. - Хэрэгжилт 100 хувь.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, хэлтэс, албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулан үр дүнгийн гэрээний загварын дагуу (гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээ, тайлан гаргах заавар, аргачлал маягтыг Засгийн газар батлахаар зохицуулагдсан бөгөөд тус аргачлал батлагдаагүй тул ийнхүү хуучнаар) боловсруулж газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллав. ТӨБЗГ болон түүний зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд 2019 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийн явцыг дүгнэж, тайлагнасан. ТӨБЗГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 10 хөтөлбөр бүхий 95 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2019 оны эхний хагас жилийн дүнгээр гарган дүгнэв. Хэрэгжилтийн явцын дүнгээс дүгнэхэд, 2019 онд төлөвлөсөн нийт 95 зорилт (арга хэмжээ)-ын хэрэгжилтийн явц дунджаар 74.3 хувийн гүйцэтгэлтэй байв. Хэрэгжилтийн дүнг тооцоходоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээний аргачлалыг баримтлан дүгнэв. “Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 %-ийн үнэлгээтэй 7, “Хэрэгжээгүй” буюу 0% үнэлгээтэй 3, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” (Үнэлэх боломжгүй) хүлээгдэж байгаа 7, нийт 17 заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч, бүрэн хэрэгжүүлэх, үр дүнд өөрчлөлт, ахиц гаргах нь зүйтэй гэж дүгнэж, удирдлагад танилцуулсан.  2.ТӨБЗГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тайлагнах, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар байгуулан ажиллуулав. Ажлын хэсэг энэ хугацаанд нийт 3 удаа танхимд хуралдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах асуудлаар зарчмын санал солилцож, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ бүрийг шинэ журам, зааврын дагуу шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон суурь түвшин, хүрэх түвшинтэй болгох, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлсон саналыг хэлтэс, албадаас авч, нэгтгэсэн төлөвлөгөөний төслийг хэлэлцэх ажлыг хийж гүйцэтгэв. ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсээс ажлын хэсгийн гаргасан шийдвэрийн дагуу тус байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулав. Шинэчлэн боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг шинээр мөрдөж байгаа журам, зааврын дагуу гаргахаар нэгтгэн боловсруулж байна. Хэлтэс, алба бүр мөн төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, тайлагнав.				
	Зарцуулсан хөрөнгө	2,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсвийн эх үүсвэр				
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> - ТӨБЗГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 74.3 хувь;				

		- ТӨБЗГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинээр мөрдөж байгаа журам, зааварт нийцүүлэн шинэчлэн боловсруулсан; - ТӨБЗГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулснаар 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шинээр мөрдөгдөж байгаа холбогдох журам, заавар, аргачлалын дагуу тайлагнах ажлыг хийх, мөн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах үндсэн шаардлагыг хангах нөхцлийг бүрдүүлж байна.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>	100 %, “Бүрэн хэрэгжсэн”	

№ 06 (61)		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.6-р арга хэмжээ</b> Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, холбогдох журмыг хэрэгжүүлэх					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар 4.1, Төрийн албаны тухай хуулийн 55 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам батлах тухай” 38 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны “Аргачлал, загвар батлах тухай” 47 дугаар тушаал.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	7,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА				
	<i>Суурь түвшин</i>	2018 оны үр дүнгийн гэрээ байгуулж, тайлагнан, дүгнэгдсэн.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Батлагдаж, тайлагнасан хугацаа, тоо, үнэлэх				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил, I, II улирлаар төлөвлөн, батлуулсан байна;</li> <li>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 6 удаа (сар бүр) тайлагнан дүгнүүлсэн байна.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил, улирлаар төлөвлөн, батлуулсан байна;</li> <li>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 12 удаа (сар бүр) тайлагнан дүгнүүлсэн байна.</li> </ul>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Газрын албан хаагчдын дунд гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг 01 дүгээр сард зохион байгуулсан боловч, Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам” батлагдаж, уг журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай аргачлал, загвар маягт батлагдсаны дараа шинээр мөрдөгдөх журмын дагуу боловсруулж батлах нь зүйтэй гэж үзэн албан ёсоор баталгаажуулах ажлыг хойшлуулсан.</p> <p>Уг загвар маягт, аргачлал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тушаалаар батлагдаж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, батлах ажил удааширсан.</p> <p>Албан хаагчдаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн дагуу хийсэн ажлыг сар бүр тайлагнуулах, нэгж, байгууллагын тайланд тусгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн. “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, түүний аргачлал, загвар маягт нэг мөр мөрдөгдөх ажил хүлээгдэж удааширсантай холбоотойгоор албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг шинээр мөрдөж байгаа журмын дагуу сар бүр дүгнээгүй болно. Тайлант оны сүүлийн улиралд албан хаагчдаар журам, аргачлалыг судлуулах, ЗГХЭГ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах асуудлаар арга зүйн сургалт, чиглэл авах ажлыг зохион байгуулж ажиллав. 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинээр мөрдөж байгаа журам, аргачлалын дагуу шинэчлэн боловсруулах, тайлагнах ажлыг нийт албан хаагчдын дунд 12 дугаар сард зохион байгуулав.</p>				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	7,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> Албан хаагчид ажлын гүйцэтгэлээ 12 удаа (сар бүр) тайлагнасан боловч дүгнээгүй. Шинээр мөрдөж байгаа журмын дагуу шинэчлэн боловсруулсан төлөвлөгөөг тайлагнах ажлыг хийж байна. Журамд заасны дагуу 2020 оны 01 дүгээр сарын 30-ны дотор Үнэлгээний баг томилон албан хаагчдын				

	ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхээр бэлтгэж байна.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>	100%, “Бүрэн хэрэгжэн”

№ 07 (62)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.7-р арга хэмжээ</b>					
	Газрын хуралдаан, Даргын Зөвлөлийн хурал, бусад хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж ажиллах					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар 4.1, 4.2, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийн 4 дүгээр бүлэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөтөлмөрийн дотоод журам”-ын 2.2, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөлийн ажиллах журам”.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	49,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан”- 30 удаа, 707 асуудал; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл” - 6 удаа, 18 асуудал. (2017, 2018 оны үзүүлэлтийн дунджаар)				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Зохион байгуулагдсан хуралдааны тоо, хэлэлцсэн асуудлын тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <p>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан”- 23 удаа, 350 асуудал; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл”- 4 удаа, 10 асуудал.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p> <p>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан”- 50 удаа, 720 асуудал; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл”- 7 удаа, 20 асуудал.</p>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ээлжит хуралдааныг 2019 онд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийн дагуу нийт 27 удаа (танхимд 25, санал авах хуудсаар 2) бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж 713 асуудал хэлэлцүүлэн, 655 тогтоол, 30 тэмдэглэлийг албажуулав. Мэдээллийн ил тод байдлыг хангаж олон нийтэд мэдээлэх зорилгоор албажуулсан тогтоол, тэмдэглэлийг байгууллагын <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> цахим хуудсанд, эд хөрөнгө актлах, устгах, дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай тогтоол, тэмдэглэлийг сар бүр шилэн дансны <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд байршуулан нээлттэй мэдээлсэн.</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-д 3 заалт шинээр нэмж, 47 заалтад найруулгын өөрчлөлт оруулах төслийг боловсруулан албан хаагчдад танилцуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхээр бэлтгэсэн.</p> <p>Мөн “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-д өөрчлөлт оруулах, орон тооны бус гишүүдэд урамшуулах олгох асуудлын төслийг боловсруулан ТӨБЗГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/991 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын даргын Зөвлөлийн хуралдааныг 2019 онд 7 удаа хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2018 оны хэрэгжилтийн тайлангийн тухай;</li> <li>2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийн тайлан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн дотоод аудит тайлан, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-д зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл, Төрийн дээд цол, одон, медальд тодорхойлох албан хаагчдын танилцуулга;</li> <li>2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд “Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлт”-д хийсэн дотоод аудитын тайлан;</li> <li>2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх үйл</li> </ol>				

		ажиллагааны зохицуулалт"-д хийсэн дотоод аудитын тайлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн заавар"-т өөрчлөлт оруулах тухай санал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж буй албан хаагчдын тухай товч танилцуулга; 5. 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай; 6. 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангийн тухай; 7. 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам", "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын төслийн тухай.
	<b>Зарцуулсан хөрөнгө</b>	49,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	<b>Хүрсэн түвшин</b>	<b>Жилийн эцэст:</b> "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан"- 27 удаа, 713 асуудлыг хэлэлцүүлсэн; "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл"- 7 удаа, 16 асуудлыг хэлэлцүүлсэн.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

<b>№ 08 (63)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.8-р арга хэмжээ</b> Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган ажиллах, албан бичгийн шийдвэрлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах					
	<b>Төлөвлөлтийн уялдаа:</b>	Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар 4.1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<b>Хэрэгжих хугацаа</b>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<b>Шаардагдах хөрөнгө</b>	10,000.0 мянган төгрөг				
	<b>Хариуцах нэгж</b>	ЗХЗХ				
	<b>Суурь түвшин</b>	Албан бичгийн эргэлтийн тоо: ирсэн 5990, явуулсан 4082 бичиг, 3758 хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 86% (2017, 2018 оны үзүүлэлтийн дунджаар)				
	<b>Шалгуур үзүүлэлт</b>	Албан бичгийн эргэлтийн тоо, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь				
	<b>Хүрэх түвшин</b>	<b>Эхний хагас жилд:</b> Ирсэн 3000, бусад байгууллагад явуулах 2100, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 85% (2017, 2018 оны үзүүлэлтийн дунджаар) <b>Жилийн эцэст:</b> Ирсэн 6000, бусад байгууллагад явуулах 4200, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 88% (2017, 2018 оны үзүүлэлтийн дунджаар)				
Арга хэмжээний хэрэгжилт	<b>Хэрэгжилт</b>	Тайлант хугацаанд, байгууллагад 6454 (газрын удирдлага-79, ЗХЗХ-569, БТУХ-1640, ТӨБХХ-2877, ХААХ-668, МТА-621) албан бичиг ирснийг байгууллагын дотоод сүлжээний <a href="http://www.able.mn">www.able.mn</a> цахим системд бүртгэн удирдлагад танилцуулж, удирдлагын заалтын дагуу дотоод сүлжээгээр хариуцсан албан хаагчдад шилжүүлэн шийдвэрлүүлж байна. Нийт 6454 албан бичгийг бүртгэж авснаас хариутай 4001 албан бичиг ирсэн. Тэдгээрийн 3771 шийдвэрлэгдэж, 104 албан бичиг хяналтад байгаа бол 126 (ГУ-28, ЗХЗХ-6, БТУХ-38, ТӨБХХ-49, ХААХ-4, МТА-1) албан бичгийн шийдвэрлэх хугацаа хэтэрсэн байна. Хариугүй 2453 албан бичиг хүлээн авч 1663 албан бичгийг шийдвэрлэсэн. Шийдвэрлэх хугацаа ойртсон, хэтэрч байгаа албан бичгийг шийдвэрлэх талаар сануулгыг 7 хоног бүр албан хаагчдад өгч, албан бичиг шийдвэрлэлтийн мэдээг гарган танилцуулж хэвшсэн. Бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд нийт 4480 албан бичгийг хүргүүлсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 304, хүний нөөцтэй холбоотой 119, нийт 423 тушаал албажин гарсан байна. Мөн 2019 оны 4 дүгээр сард "Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтэд дотоод аудит хийх" тухай удирдамжийг ТӨБЗГ-ын даргаар батлуулан аудит хийж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл болон нийт албан хаагчдад танилцуулж, холбогдох хууль, журам, зааврын мөрдөлтийг сайжруулах арга хэмжээ авч, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт" өөрчлөлт оруулах үүрэг зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн дагуу уг зааврын төсөлд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааг багасган, асуудлыг шуурхай шийдвэрлэж байх агуулгыг тусган шинэчлэн боловсруулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөлд төслийг танилцуулж, саналыг тусган,				

		албажуулахаар бэлтгэв.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	10,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> Ирсэн 6454, бусад байгууллагад явуулах 4480, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 94.0 хувийн дүнтэй байна.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

№ 09 (64)	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.9-р арга хэмжээ</b>					
	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар 4.1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	10,000.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	2018 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад ТӨБЗГ нь нийт 55 хэрэг хөтлөгдөхөөр батлагдсан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлагдсан байх, улсын үзлэгийн үнэлгээ				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлагдаж, улсын үзлэгт бэлтгэсэн байна. <b>Жилийн эцэст:</b> 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлагдаж, улсын үзлэгт 85 дээш оноогоор үнэлэгдсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2019 оны шийдвэрээр байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байнга хадгалах 28, түр хадгалах 25, 70 жил хадгалах 2, нийт 55 хэрэг хөтлөгдөхөөр баталсан. 2019 онд "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" явагдахтай холбогдуулан тус үзлэгт бэлтгэх, төв болон салбар комиссыг үзлэг явуулахад дэмжлэг үзүүлэх, үзлэгт бэлдсэн ажлын талаар төв болон салбар комиссыг мэдээллээр хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар байгуулан улсын үзлэгт хамрагдах бэлтгэл хангуулах ажлыг зохион байгуулсан. "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-т 84.3 хувийн үнэлгээтэй дүгнүүлсэн.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	10,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт нийт 55 хэрэг хөтлөгдөхөөр шийдвэрлэгдсэн батлагдаж, улсын үзлэгт 84.3 хувийн оноогоор үнэлэгдсэн.				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"				

№ 10 (65)	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.10-р арга хэмжээ</b>					
	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, судлах, шийдвэрлүүлж, тайлагнах					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.1.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	6,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	210 өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэлт 91%, тайлагналт улирал бүр (2017, 2018 оны үзүүлэлтийн дунджаар)				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Шийдвэрлэлтийн болон хугацаа хэтрэлтийн хувь, тайлагналтын хугацаа				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> 120 өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэлт 91%, хугацаа хэтрэлт 9% (бусад байгууллагатай хамтран шийдвэрлэхтэй холбогдуулан), тайлагналт улирал бүрийн дараа сарын эхний 7 хоног. <b>Жилийн эцэст:</b> 200 өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэлт 92%, хугацаа				



		хэтрэлт 8% (бусад байгууллагатай хамтран шийдвэрлэхтэй холбогдуулан), тайлагналт улирал бүрийн дараа сарын эхний 7 хоног.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, ТӨБЗГ 209 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч, байгууллагын дотоод сүлжээ <a href="http://www.able">www.able</a> цахим системд бүртгэн, удирдлагын заалтын дагуу албан хаагчид хуваарилан хүргүүлснээс шийдвэрлэгдсэн 169, хяналтад 27, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байгаа 13 өргөдөл, гомдол байна. Мөн ТӨБЗГ-г иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2018 оны жилийн эцэс, 2019 оны I, II, III дугаар улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын цахим хуудсанд байршуулан мэдээлсэн. Мөн 2019 оны 4 дүгээр сард “Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтэд дотоод аудит хийх” тухай удирдамжийг ТӨБЗГ-ын даргаар батлуулан 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг хамруулан аудит хийж, тайланг газрын Даргын зөвлөл болон нийт албан хаагчдад танилцуулж, холбогдох хууль, журам, зааврын мөрдөлтийг сайжруулах арга хэмжээг авсан. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт” өөрчлөлт оруулах талаар аудитын зөвлөмжийг өгсөн. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангахаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт” өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан.
	Зарцуулсан хөрөнгө	6,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> 209 өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэлт 82%, хяналтад авсан 12%, хугацаа хэтрэлт 6% (бусад байгууллагатай хамтран шийдвэрлэхтэй холбоотой болон бусад шалтгаанаар) байна. Улирал бүрийн дараа сарын эхний 7 хоногт тайлагнасан.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100%, “Бүрэн хэрэгжсэн”

№ 11 (66)	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.11-р арга хэмжээ</b> Албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	25,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ, Олон нийтийн ажил зохион байгуулах комисс				
	Суурь түвшин	2018 онд комисс байгуулагдсан, төлөвлөгөөний хэрэгжилт 90%				
	Шалгуур үзүүлэлт	Комисс байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилт				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> 2019 онд комисс байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилт 60% <b>Жилийн эцэст:</b> 2019 онд комисс байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилт 100%				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	ТӨБЗГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар байгууллагын албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах комиссыг байгуулсан. Тус комисс нь 5 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс дараах 4 арга хэмжээг зохион байгуулсан байна: <ul style="list-style-type: none"> <li>- 05 дугаар сарын 30-ны өдөр “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан албан хаагчдын 102 хүүхдэд бэлэг өгөх;</li> <li>- 09 сарын 25-ны өдөр Ахмадын баярыг тохиолдуулан 23 ахмадад хүндэтгэл үзүүлэх;</li> <li>- 09 сарын 28-ны өдөр нийт албан хаагчдын дунд “Алтан намар” арга хэмжээ;</li> <li>- 12 дугаар сарын 20-ны өдөр “Шинэ жил”-ийн арга хэмжээ.</li> </ul> Албан хаагчдын дунд “Спортын арга хэмжээ” зохион байгуулаагүй байна. Тус комисс төлөвлөгөөт арга хэмжээнээс гадна 01 дүгээр сарын 25-ны өдөр “Цагаан сар”-ыг тохиолдуулан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, 02 дугаар сарын 11-ний өдөр албан хаагчдын золголт, 7 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баярт зориулсан арга хэмжээг бэлтгэн зохион байгуулсан.				
	Зарцуулсан хөрөнгө	25,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> 2019 онд комиссыг байгуулсан бөгөөд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна.				

<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100%, "Бүрэн хэрэгжсэн."				
<b>№ 12 (67)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.12-р арга хэмжээ</b>					
	"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	7,500.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ				
	Суурь түвшин	2018 оны хэрэгжилт - 86%				
	Шалгуур үзүүлэлт	Сургалтын төлөвлөгөө батлах, төлөвлөгөөний хэрэгжилт				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Төлөвлөгөө боловсруулан батлах, хэрэгжилт 60% <b>Жилийн эцэст:</b> Төлөвлөгөө боловсруулан батлах, хэрэгжилт 100%				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/107 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ТӨБЗГ-ын албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөг 22 агуулгын хүрээнд боловсруулан ТӨБЗГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/48 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлэв. Сургалтын төлөвлөгөөний дагуу тайлант жилд нийт 22 лекц, сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 357 албан хаагчийг хамруулан 608.8 сая төгрөгийг зарцуулсан. Сургалтыг агуулгаар нь ангилан харуулбал. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны тухай хууль, дүрэм журмын сургалт 2;</li> <li>- Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт 2;</li> <li>- Хүний нөөцийн бодлого, удирдлагын сургалт 1;</li> <li>- Авлигын эсрэг хууль тогтоомжтой холбоотой сургалт 3;</li> <li>- Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайллын талаарх сургалт 2;</li> <li>- Худалдан авах ажиллагаатай холбоотой дотоод сургалт 1;</li> <li>- Бусад чиглэлээр хуулийн мэдлэг олгох 2;</li> <li>- Дотоод аудитын сургалт 1;</li> </ul> <p>Соён гэгээрүүлэх, хөрөнгийн зах зээл зэрэг бусад чиглэлээр 8 сургалт зохион байгуулсан байна.</p> <p>Төлөвлөгөөт бусаар нийт 13 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 216 албан хаагчийг хамруулж, шинэ мэдлэг мэдээлэл олгосон бөгөөд үүнд 298.8 мянган төгрөг зарцуулсан байна.</p>				
	Зарцуулсан хөрөнгө	7,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв. Сургалтын зардалд нийт 907.6 мянган төгрөг.				
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> ТӨБЗГ-ын албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөг 22 (100%) агуулгын хүрээнд боловсруулан ТӨБЗГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/48 дугаар тушаалаар батлуулж, тус төлөвлөгөөний хэрэгжилтийг 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хангасан.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100%, "Бүрэн хэрэгжсэн"				

<b>№ 13 (68)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.13-р арга хэмжээ</b>					
	"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	9,200.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ				
	Суурь түвшин	2018 онд 263 албан хаагч (давхардсан тоогоор)				
	Шалгуур үзүүлэлт	Төсөвтэй уялдан албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсан байх				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> 80 албан хаагчийн нийгмийн баталгаа хангагдана				

		<b>Жилийн эцэст:</b> 170 албан хаагчийн нийгмийн баталгаа хангагдана (давхардсан тоогоор)
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	<i>Хэрэгжилт</i>	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/108 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар 7 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ЗГХЭГ-ын даргын 2018 оны 135, 158 дугаар тушаалаар нийт 33 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон шинэчлэн тус тус олгож, Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар Улсын ахлах байцаагчийн цол олгогдсоныг үндэслэн 1 албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн шатлалыг шинэчилсэн.</li> <li>- Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах зорилгоор Улсын 2 дугаар төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт “Хамтран ажиллах тухай” ТӨБЗГ-ын А-1/1034, 1036 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.</li> <li>- Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 8 албан хаагчид тус бүр 100.0 мянга, шинээр гэр бүл болсон 1 албан хаагчид 200.0 мянга, нийт 1.0 сая төгрөгийн тэтгэмж, гэр бүлийн гишүүн нь хүндээр өвдсөн болон нас барсан 3 албан хаагчид тус бүр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх, гэр бүлд нь гачигдал тохиолдсон 1 албан хаагчид 2 сарын үндсэн цалинтай тэнцэх, 5 албан хаагчид эрүүл мэндийн шалтгаанаар 7 хоногоос 3 сар хүртэлх сарын хугацаатай тэтгэмжтэй чөлөө, 5 албан хаагчид их, дээд сургуульд суралцах хугацаанд нь цалинтай чөлөө тус тус олгосон.</li> <li>- Ар гэрт нь гачигдал тохиолдсон 4 албан хаагчид 200.0 мянган төгрөг, гэр хороололд шугам сүлжээнд холбогдоогүй байр орон сууцанд амьдардаг 3 албан хаагчид тус бүр 300.0 мянга, Эх үрсийн баяраар албан хаагчдын 102 хүүхдэд нийт 2.1 сая, Ахмадын баярыг тохиолдуулан 25 ахмад настанд 3.3 сая, төрийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байгаа 2 албан хаагчид 50 насны ойг тохиолдуулан тус бүр 50.0 мянган төгрөг, нийт 7.2 сая төгрөгийг олгосон. Мөн 8 албан хаагчид 72.6 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. 15 албан хаагчид 1.8 сая төгрөгийн шагналын мөнгөн урамшуулал олгосон.</li> </ul> <p>2019 онд 106 (давхардсан тоогоор) албан хаагчийн нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэж, нийт 82.5 сая төгрөгийн тусламж, дэмжлэг олгосон байна. Тайлант хугацаанд, нийт 170 (давхардсан тоогоор) албан хаагчийн нийгмийн баталгааг хангахаар төлөвлөсөн боловч 33 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон шинэчлэн олгосонтой холбогдуулан ТӨБЗГ-ын 2019 оны цалингийн санд хүндрэл учирч албан хаагчдад урамшуулал олгогдоогүй болно.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	82.5 сая төгрөг
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> 106 албан хаагчийн нийгмийн баталгаа хангах арга хэмжээнд 82.5 сая төгрөгийн тусламж, дэмжлэг олгов.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>	100 %, “Бүрэн хэрэгжсэн”	

<b>№ 14 (69)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.14-р арга хэмжээ</b>					
	2018 оны “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	1,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	2017 онд тайлагнасан, хугацаандаа				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Тайлагнах, хугацаа				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b> 2018 оны тайланг Төрийн албаны зөвлөлийн тогтоосон хугацаанд тайлагнан, хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> -</p>				
<b>Арга хэмжээний</b>	<i>Хэрэгжилт</i>	2018 оны “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г хүний нөөцийн системд оруулан, мэдээллийг 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, явцын өөрчлөлтийн мэдээг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр тус тус гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн баталгаажуулсан.				

<b>хэрэгжилт</b>	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	1,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	2018 оны “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г хүний нөөцийн системд оруулан, мэдээллийг 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, явцын өөрчлөлтийн мэдээг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр тус тус гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн баталгаажуулсан.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”

<b>№ 15 (70)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.15-р арга хэмжээ</b> Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлах					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	1,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ, Ажлын хэсэг				
	<i>Суурь түвшин</i>	Ажлын байрны тодорхойлолт 2016 онд батлагдан мөрдөгдөж байгаа				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Албан тушаалын тодорхойлолт батлагсан байх				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> - Байгууллагын чиг үүргийн шинжилгээг хийх; - Албан тушаалын тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулах; - Албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-аар хянуулах, зөвшөөрөл авах; - Батлах.  <b>Жилийн эцэст: -</b>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Байгууллагын стратеги төлөвлөгөө, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах, байгууллага, нэгжийн чиг үүргийн иж бүрэн шинжилгээ, ажлын байрны шинжилгээ хийх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 1.5, 3.3-т заасны дагуу байгууллага, нэгжийн чиг үүргийн шинжилгээг хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/86 дугаар тушаалаар байгуулан ажиллуулсан. Ажлын хэсгээс зохион байгуулсны дагуу чиг үүргийн шинжилгээг зохион байгуулалтын нэгж бүр хийсэн. Ажлын хэсгээс иж бүрэн шинжилгээг нэгтгэж, чиг үүргийн давхардал, хийдлийг судлан, дүгнэлт гаргасны дүнд байгууллага, албан хаагчдын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн чиг үүргийн дахин хуваарилалтыг хийх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэсэн.  Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуульд 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны 438 дугаар тогтоолоор Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиг үүрэг салж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар байгуулагдаад байна. Үүнтэй холбоотойгоор ТӨБЗГ-ын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт өөрчлөлт орохоор байгаа тул дээд шатны байгууллагын шийдвэр гарах хүртэл албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажил хүлээгдэж байна.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	1,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> - Байгууллагын чиг үүргийн шинжилгээг 2019 оны 04 дүгээр сард хийсэн; - Газрын даргын албан тушаалын тушаалын тодорхойлолтын төсөл, холбогдох баримт материалыг бэлтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуульд 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан албан тушаалын тодорхойлолт боловсруулах асуудал хүлээгдэж буй талаар ТАЗ-өөс чиглэл авч, хянуулах, батлах зөвшөөрөл авах асуудлыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэх агентлаг шинээр байгуулагдах хүртэл хойшлуулсан. Иймээс албан тушаалын тодорхойлолтыг шинээр гарсан хууль тогтоомж, журам зааварт ницүүлэн боловсруулж батлуулах ажил хүлээгдэж байна.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		70%, “Хэрэгжих шатанд”				

№ 16 (71)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.16-р арга хэмжээ</b> Албан хаагчдын хариуцлагыг чангатгаж, хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан албан хаагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, хэрэгжилтийг хангах					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.1.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	3,500.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ				
	Суурь түвшин	2018 онд 1 албан хаагчид хариуцлага тоосон.				
	Шалгуур үзүүлэлт	- Хариуцлага хүлээсэн албан хаагчийн тоо; - Холбогдох журмын хэрэгжилт, хувиар.				
Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулах; - Хэрэгжилтийг хангуулах; - Ёс зүйн зөвлөл байгуулах. <b>Жилийн эцэст:</b> Тайлагнах, хэрэгжилт - 90-100 %.					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг сайжруулах, сахилга хариуцлагыг чангатгах зэрэг асуудлыг тодорхой болгох зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг тушаалын 7.2.3-т “Ажлын байр, хууль, журмаар тогтоосон албан үүрэгтэй холбоотой газар ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглоно”, 9.2.4-д “Албан хаагч нь нэг сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 цагаас дээш хугацаагаар хоцорсон, бүртгүүлээгүй тохиолдолд 1 өдрийн ажил тасалсанд тооцно”, 9.2.7-д “Захиргаа, хууль зүйн нэгж нь албан хаагчийн цагийн бүртгэлийг системийн дагуу баталгаажуулах бөгөөд уг бүртгэл нь цалин хөлсийг тооцох үндэслэл болно”, 9.2.8-д “Албан хаагч нь сард 1 өдөр ба түүнээс дээш хугацаагаар ажил тасалсан нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” зэрэг өөрчлөлтүүдийг оруулан хэрэгжилтийг хангах арга хэмжээ аван ажиллаж байна.  Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн 1 албан хаагчийг албан тушаал бууруулж, 1 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлж, удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас хоцорч ирцийн бүртгэл дутуу, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, ажлын цагийн хоцрогдолтой зөрчил гаргасан 1 албан хаагчид албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаатайгаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулж, 1 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн. Мөн ТӨБЗГ-ын “Ёс зүйн зөвлөл”-ийг газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар байгуулж, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдүүлэн ажиллаж байна.				
	Зарцуулсан хөрөнгө	3,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулсан; - Зөрчил, дутагдал гаргасан 2 албан хаагчид хариуцлага тооцсон; - “Ёс зүйн зөвлөл”-ийг газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар байгуулсан.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”				

№ 17 (72)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.17-р арга хэмжээ</b> Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар арга хэмжээ зохион байгуулах					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал

шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө	1,500.0 мянган төгрөг
	Хариуцах нэгж	ЗХЗХ
	Суурь түвшин	-
	Шалгуур үзүүлэлт	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо, Хэрэгжилт, хувиар
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг хангах; - Ажлын байрны зураг авалт хийх; - Зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцох. <b>Жилийн эцэст:</b> Тайлагнах, хэрэгжилт - 90-100 % байна.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг сайжруулах, сахилга хариуцлагыг чангатгах зэрэг асуудлыг тодорхой болгох зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг тушаалын 7.2.3-т “Ажлын байр, хууль, журмаар тогтоосон албан үүрэгтэй холбоотой газар ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглоно”, 9.2.4-д “Албан хаагч нь нэг сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 цагаас дээш хугацаагаар хоцорсон, бүртгүүлээгүй тохиолдолд 1 өдрийн ажил тасалсанд тооцно”, 9.2.7-д “Захиргаа, хууль зүйн нэгж нь албан хаагчийн цагийн бүртгэлийг системийн дагуу баталгаажуулах бөгөөд уг бүртгэл нь цалин хөлсийг тооцох үндэслэл болно”, 9.2.8-д “Албан хаагч нь сард 1 өдөр ба түүнээс дээш хугацаагаар ажил тасалсан нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” зэрэг өөрчлөлтүүдийг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилгоо хангалтгүй биелүүлсэн 1 албан хаагчийг албан тушаал бууруулж, 1 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлж, удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас хоцорч ирцийн бүртгэл дутуу, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, ажлын цагийн хоцрогдолтой зөрчил гаргасан 1 албан хаагчид албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаатайгаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулж, 1 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн. Байгууллагын стратеги төлөвлөгөө, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах, байгууллага, нэгжийн чиг үүргийн иж бүрэн шинжилгээ, ажлын байрны шинжилгээ хийх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 1.5, 3.3-т заасны дагуу байгууллага, нэгжийн чиг үүргийн шинжилгээг хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/86 дугаар тушаалаар байгуулан ажиллуулав. Ажлын хэсгээс зохион байгуулсны дагуу чиг үүргийн шинжилгээг зохион байгуулалтын нэгж бүр хийж, ажлын хэсэг иж бүрэн шинжилгээг нэгтгэн, чиг үүргийн давхардал, хийдлийг судлан, дүгнэлт гаргасны дүнд байгууллага, албан хаагчдын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн чиг үүргийн дахин хуваарилалтыг хийх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэсэн.
	Зарцуулсан хөрөнгө	1,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна; - Ажлын байрны зураг авалт хийгээгүй; - Зөрчил, дутагдал гаргасан 2 албан хаагчид хариуцлага тооцсон.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”

№ 18 (73)	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.18-р арга хэмжээ</b> Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн шатлал нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох асуудлыг шийдвэрлэх					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	165,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ				

	Суурь түвшин	- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 5 албан хаагч; - Цалингийн шатлал, зэрэглэл нэмэгдүүлсэн 3 албан хаагч.
	Шалгуур үзүүлэлт	Нэмэгдэл, шатлал, зэрэг дэв олгогдсон албан хаагчын тоо
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - Судалгаа гаргах; - Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 7 албан хаагч хамрагдана; - Албан тушаалын зэрэг дэв олгогдох 31 албан хаагч.  <b>Жилийн эцэст:</b> Хэрэгжилтийг ханган тайлагнах, хэрэгжилт - 100 %.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	ЗГХЭГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 135, ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 158 дугаар тушаалаар 33 албан хаагчид зэрэг дэв шинээр болон шинэчлэн олгож, 7 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.  Албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн судалгааг 2019 оны 01 дүгээр сард шинэчлэн гаргаж, 2019 онд "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу 5 албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулах хүсэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-1/351 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.
	Зарцуулсан хөрөнгө	165,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> - Албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн судалгааг 2019 оны 01 дүгээр сард шинэчлэн гаргасан; - Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 7 албан хаагч хамрагдсан; - Албан тушаалын зэрэг дэвийг холбогдох шийдвэрийн дагуу нийт 33 албан хаагчид шинээр болон шинэчлэн олгосон.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

№ 19 (74)	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.19-р арга хэмжээ</b> Газрын хүний нөөцийн асуудлаар судалгаа хийх					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.3.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	1,500.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ				
	Суурь түвшин	2018 онд ажилласан жил, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн алба хаасан хугацаа, боловсрол, мэргэжил, орон сууц, хүүхдийн судалгаа хийгдсэн.				
	Шалгуур үзүүлэлт	Судалгааны тоо, түүний үр дүн				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - Ажилласан жил, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн алба хаасан хугацаа, боловсрол, мэргэжил, орон сууц гэх мэт; - Судалгааны үр дүнг үндэслэн албан тушаалын ангилал, зэрэглэл нэмэгдүүлэх; - зэрэг дэв олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, сургалтад хамруулах, нийгмийн асуудал шийдвэрлэх гэх мэт,  <b>Жилийн эцэст:</b> Хэрэгжилтийг ханган тайлагнах, хэрэгжилт – 100%.				
Арга хэмжээний хэрэгжилт	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын хэрэгжилтийг хангах болон 2020 оны төсвийн төсөл боловсруулах ажлын хүрээнд албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн судалгаа, албан хаагчдын 2019 оны ээлжийн амралт олгох ажлын хүрээнд ажилласан жилийн судалгаа, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын орон сууцны хөтөлбөр"-ийн төсөл боловсруулах ажлын хүрээнд албан хаагчдын орон сууцны судалгаа, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд албан хаагчдын хүүхдийн судалгаа зэргийг гаргасан. Мөн "Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан"-г шинэчлэн Төрийн албаны зөвлөлд, төрөөс хөнгөлөлттэй зээлээр их, дээд сургуульд суралцсан албан хаагчдын талаарх судалгааг гарган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Зээлийн санд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж буй талаарх судалгааг Төрийн албаны зөвлөлд, сайжруулсан шахмал түлшний хөнгөлөлтөд хамрагдах албан хаагчдын судалгааг гарган "Таван толгой түлш" ХХК-д тус тус хүргүүлсэн.					

	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	1,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> - Ажилласан жил, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн алба хаасан хугацаа, боловсрол, орон сууц, хүүхдийн судалгаа хийгдсэн; - Судалгааны үр дүнг үндэслэн 1 албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл нэмэгдүүлж, 33 албан хаагчид зэрэг дэв шинээр болон шинэчлэн олгож, 7 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгож, давхардсан тоогоор 573 албан хаагчийг сургалтад хамруулж, 106 албан хаагчийн нийгмийн асуудал шийдвэрлэж, 102 хүүхдэд бэлэг өгсөн.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.1.-ийн үр дүн:** Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангагдсан байна.

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.1.</b> Төрийн албаны тухай хуулийн (шинэчилсэн найруулга) хэрэгжилт	Хувь	-	50	57.5	100	77.5
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.2.</b> Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд дэмжлэг, тусламж хүртсэн албан хаагчид	Тоо	263 (давхардсан тоогоор)	80 (давхардсан тоогоор)	64 (давхардсан тоогоор)	170 (давхардсан тоогоор)	106 (давхардсан тоогоор)
3.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.3.</b> Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	86	50	63	100	82
4.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.4.</b> Авлига, ашиг сонирхлын зөрчөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээний хамрагдалт (ТӨБЗГ-ын албан хаагч, төлөөлөл хэрэгжүүлдэг ТӨХЭ)	тоо	560	265	1508 (Давхардсан тоогоор)	561	1551 (Давхардсан тоогоор)
5.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.5.</b> Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (тухайн жилийн тайланг дараа оны 1-р сард тайлагнадаг)	хувь	70 (2017 он)	80< (2018 он)	87.5 (2018 он)	80< (2018 он)	87.5 (2018 он)
6.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.6.</b> Хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Хувь	88.5	88	85.3	90	88

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ЗХЗХ

**Гүйцэтгэлийн зорилт №3.2.2.** Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх замаар менежментийг сайжруулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

№ 20 (75)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.1-р арга хэмжээ</b> Гадаадын улс орнуудын худалдан авах ажиллагааны болон төрийн өмчийн бүртгэл хяналтын системийн цаашдын хөгжил, чиг хандлага, хууль, эрх зүй, технологийн шийдлийн талаар судалгаа хийж, сайн туршлагыг нэвтрүүлэх					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратегийн зорилт 4.5.				
Гүйцэтгэлийн шалгуур	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шардагдах хөрөнгө</i>	15,000.0 мянган төгрөг				



үзүүлэлт	Хариуцах нэгж	МТА
	Суурь түвшин	- Хөгжингүй 3 орны сайн туршлага судалсан;
	Шалгуур үзүүлэлт	- Хөгжингүй орны мэдээллийн системийн харьцуулсан дүгнэлт хийх; - Шинэ ололт, чиг хандлага, сайн туршлагыг судлах; - Нэвтрүүлж болох сайн туршлагын талаар санал дэвшүүлэх; - Жилдээ.
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Хэрэгжилт – 50%. <b>Жилийн эцэст:</b> - Хөгжлийн түвшинг харьцуулан тодорхойлсон байна; - Дүгнэлт гаргасан байна; - Хэрэгжилт – 100%.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Шведийн вант улсын худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээ байгуулах ажлын туршлага судлах, семинарт оролцох чиглэлээр МТА-ны дарга Н.Цэрэнсамбуу, ахлах мэргэжилтэн С.Халиун нар 03 дугаар сарын 23-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал албан томилолтоор ажилласан. Туршлага судлах, сургалт семинарын үеэр Швед улсын худалдан авах ажиллагааны газар (National Procurement Services), Шударга өрсөлдөөний газар (Swedish Competition Authority), Бүс нутгийн худалдан авах ажиллагааны газар (Central purchasing body), Сангийн яам зэрэг байгууллагуудад ажиллаж, ерөнхий гэрээ байгуулж, хэрхэн үр ашигтай худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа байдал, давуу болон сул тал, цаашид анхаарах хүчин зүйлсийн талаар туршлага судалсан.  Энэтхэгийн засгийн газрын санхүүжилтээр Бүгд Найрамдах Энэтхэг ард улсын Энэтхэгийн техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдан Дэд бүтэц, технологийн төслийн менежмент, олон улсын менежментийн хөгжил сэдэвт хөтөлбөрт мэргэжилтэн Д.Бадрах хамрагдан туршлага судалсан.  Энэтхэгийн засгийн газрын санхүүжилтээр Бүгд Найрамдах Энэтхэг ард улсын Энэтхэгийн техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдан “Big Data Analysis” сэдэвт хөтөлбөрт ахлах мэргэжилтэн С.Халиун хамрагдан туршлага судалсан.  2019 оны 04 сарын 22-ны өдөр Нээлттэй засгийн түншлэлийн Multi Donor Trust Fund-д Гэрээний хэрэгжилтийг ил болгох, нээлттэй гэрээний олон улсын стандартыг нэвтрүүлэх чиглэлээр төслийн санал боловсруулж хүргүүлсэн.
	Зарцуулсан хөрөнгө	15,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсвийн эх үүсвэр
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> 3 удаагийн давтамжтайгаар 2 орны туршлага судалсан.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”

№ 21 (76)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.2-р арга хэмжээ</b> Газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, албан хаагчдад мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх					
	Төлөөлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 4.1, 4.5.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	7,500.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	МТА				
	Суурь түвшин	- Байгууллагын дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангасан; - Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулсан; - Албан хаагчдад мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажилласан.				
	Шалгуур үзүүлэлт	- Байгууллагын болон албан хаагчдын дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаа хангагдсан байх.				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Хэрэгжилт – 100%. <b>Жилийн эцэст:</b> - Байгууллагын дотоод болон гадаад цахим сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангасан байна; - Албан хаагчдад мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна. - Хэрэгжилт – 100%.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	- Байгууллагын баруун жигүүрийн сүлжээ тасарсан шалтгааныг тодорхойлж шаардлагатай тоног төхөөрөмжийг сольж хэвийн ажиллагаанд оруулсан. - Үндэсний Дата төв УТҮГ-т байрших Худалдан авах ажиллагааны цахим системийн сервер тоног төхөөрөмжид гарсан гэмтлийн шалтгааныг тодорхойлж шаардлагатай тоног төхөөрөмжийг сольж, хэвийн ажиллагаанд оруулсан.				

		<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинэчилж, хэвийн ажиллагаанд оруулсан.</li> <li>- Байгууллагын албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, шинэчлэх шаардлага бүхий 30 албан хаагчийн компьютер, 9 албан хаагчийн принтерийг шинээр сольсон.</li> <li>- Байгууллагын болон албан хаагчдын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд нийт 42 компьютерийн хэвийн үйл ажиллагааг хангах үйлчилгээ үзүүлж, бусад тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тухай бүрд ханган ажилласан.</li> <li>- Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн тус газрын дотоод сүлжээнд хорт код илэрсэн тухай зөвлөмж ирүүлсний дагуу вирусны программ худалдан авах ажиллагааг зохион байгуулж, байгууллагын дотоод сүлжээнд холбогдсон тоног төхөөрөмж бүрт вирусны эсрэг программ суулгасан.</li> <li>- Албан хаагчдад тулгарч буй мэдээллийн технологийн асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгийг тухай бүр хүргэн ажилласан.</li> </ul>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	7,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсвийн эх үүсвэр
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> Байгууллагын болон албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийн дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг бүрэн хангасан. Албан хаагчдад тулгарч буй мэдээллийн технологийн асуудлыг шийдвэрлэхэд тухай бүр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангасан.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"

№ 22 (77)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.3-р арга хэмжээ</b> Албан хэрэгцээнд дотоод сүлжээний <a href="https://www.able.mn">https://www.able.mn</a> e-office системийн хэрэглээг сайжруулах					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратегийн зорилт 4.1, 4.5.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	15,000.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	МТА				
	<i>Суурь түвшин</i>	- 73 албан хаагч.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим систем ашиглаж буй албан хаагчдын тоо;</li> <li>- Удирдлагын мэдээллийн нэгдмэл байдал хангагдах нөхцөл бүрдэх;</li> <li>- Хэрэгжилт, хувиар.</li> </ul>				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Хэрэгжилт – 100%. <b>Жилийн эцэст:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Эйбл софт дотоод сүлжээний хэрэглээ сайжирсан байна;</li> <li>- Албан хаагчдын гүйцэтгэлд тавих хяналт сайжирна.</li> <li>- Хэрэгжилт – 100%.</li> </ul>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Эйбл Софт системтэй холбоотой албан хаагчдад тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө, тусламж хүргэн ажилласан.</li> <li>- Шинээр нэмэгдсэн болон хасагдсан албан хаагчдын мэдээллийг системд оруулж нэвтрэх нэр, нууц үгийн эрхийг тохируулсан.</li> <li>- Цахилгааны хэлбэлзэл болон цахилгааны тасалдлаас болж албан хаагчдын цаг бүртгэлийн мэдээлэл хурууны хэзний төхөөрөмжөөс Эйбл Софт системд бүртгэгдээгүй асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажилласан.</li> <li>- Хуучин цаг бүртгэлийн төхөөрөмжийг сольж, албан хаагчдын цаг бүртгэл Эйбл Софт системд тасалдалгүй, үнэн зөв, зөрүүгүй бүртгэгдэх боломжийг бий болгосон.</li> <li>- Эйбл Софт системийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан тухай бүрд хариуцсан байгууллагад мэдэгдэж, хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг авч ажиллав.</li> </ul>				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	15,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсвийн эх үүсвэр				
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> Эйбл Софт системийг ашигласнаар албан хаагчид, удирдлагын мэдээллийн нэгдмэл байдал хангагдаж, ажлын бүтээмж, гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"				

№ 23 (78)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.4-р арга хэмжээ</b> Байгууллагын хяналтын камерын хэвийн жигд ажиллагааг хангах					

нэр, дугаар	Төлөөлөлтийн уялдаа:	Стратегийн зорилт 4.1, 4.5.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шардагдах хөрөнгө	10,000.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	МТА				
	Суурь түвшин	- Камерын хэвийн ажиллагааг хангаж ажилласан; - Камерын тоо 14.				
	Шалгуур үзүүлэлт	- Камерын хэвийн ажиллагаа; - Камерын тоо.				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Хэрэгжилт – 100%. <b>Жилийн эцэст:</b> - Байгууллагын хяналтын камерын хэвийн ажиллагаа хангагдсан байна; - Байгууллагын дотоод хяналт сайжирсан байна; - Хэрэгжилт – 100%.				
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	Хэрэгжилт	- Шаардлагатай үед хяналтын камерын бичлэгийг эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөх, үзүүлэх арга хэмжээ авч ажилласан. - Байгууллагын баруун жигүүрийн сүлжээ тасарсны улмаас хяналтын камер ажиллагаагүй болсон бөгөөд холболт, тохиргоог дахин хийж, хэвийн ажиллагаанд оруулсан. - Байгууллагын 4 хяналтын камерын тэжээл шатсан бөгөөд цахилгааны асуудлыг шийдвэрлэж өгөх тухай Байрын захиргаанд мэдэгдэж, хүсэлт гарган цаг алдалгүй арга хэмжээ авч хэвийн байдалд оруулсан.				
	Зарцуулсан хөрөнгө	10,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын төсвийн эх үүсвэр				
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> Жилийн дүнгээр, давхардсан тоогоор 24 хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”				

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.2.-ын үр дүн:** Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад нэвтрүүлсэн байна.

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.2.1.</b> Технологийн ололт, сайн туршлагыг судлах улс орон	тоо	3	2	1	4	3
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.2.2.</b> Байгууллагын болон албан хаагчдын дотоод болон гадаад цахим сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа	Чанар: Хэрэгжилтийн хувь	Байнгын хэвийн ажиллагаа, 100	Байнгын хэвийн ажиллагаа, 100	Байнгын хэвийн ажиллагаа, 100	Байнгын хэвийн ажиллагаа, 100	Байнгын хэвийн ажиллагаа, 100
3.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.2.3.</b> Цахим систем, дотоод сүлжээ ашиглагч албан хаагч	тоо	73	73	73	73	73
4.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.2.4.</b> Байгууллагын камерын хэвийн ажиллагаа, ажиллуулах камер	Чанар: Хэрэгжилтийн хувь, тоо	Байнгын хэвийн ажиллагаа, 100, 14	Байнгын хэвийн ажиллагаа, 100, 14	Байнгын хэвийн ажиллагаа, 100, 14	Байнгын хэвийн ажиллагаа, 100, 14	Байнгын хэвийн ажиллагаа, 100, 14

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын МТА

**НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ № 2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ГАДААД ХАРИЛЦАА**

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.3.** Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах

№ 24 (79)	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>
Арга хэмжээний	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.3.1-р арга хэмжээ</b> Газрын үйл ажиллагааг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд

нэр, дугаар	хүргэх, сурталчлах					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.1.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	25,000.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	2018 онд 267 (давхардсан тоогоор) зар, мэдээ, мэдээлэл, ярилцлагыг 383 (давхардсан тоогоор) хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллага болон олон нийтэд хүргэсэн зар, мэдээ, мэдээллийн тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> - Хамтран ажиллах байгууллага сонгон шалгаруулах, гэрээ байгуулах; - 270 зар, мэдээ, мэдээлэл бэлтгэх; - 380 хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх.  <b>Жилийн эцэст:</b> Тайлагнах, хэрэгжилт 100%.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудлын хүрээнд байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим хуудсанд 53 мэдээ, мэдээлэл, 8 дуудлагын худалдааны зар, 1 сонгон шалгаруулалтын зар, 10 ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах зар байршуулсан. Олон нийтэд 121 мэдээ мэдээлэл, телевизийн 8 тодруулга ярилцлага, телевизийн 5 нэвтрүүлэгт холбогдох албан хаагч оролцож, мэдээ мэдээлэл нийтлүүлсэн. Нийт 152 цахим хуудас, 187 телевиз, 14 өдөр тутмын сонин, 6 радиотой хамтран ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэн нэвтрүүлж, сурталчилсан. Сонгогдсон өдөр тутмын 3 сонинд 259 удаа тендерийн урилга нийтэлж, олон нийтэд мэдээлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар болон төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, танилцуулах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцож, мэдээллийг 4 өдөр тутмын сонин 12 телевиз, 16 цахим сайтаар мэдээлсэн.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	25,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> - 466 зар, мэдээ, мэдээлэл бэлтгэсэн; - 377 (давхардсан тоогоор) хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100 %, "Бүрэн хэрэгжсэн"				

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.3.-ийн үр дүн:** Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл олон нийтийн хүртээл болж, нээлттэй мэдээлэгдсэн байна.

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			2018 он	Эхний хагас жил		Жилийн эцэс	
				Төл	Гүй	Төл	Гүй
1.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.3.1.</b> Олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээлэл	Удаа/тоо	267	150	185	270	466
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.3.2.</b> Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллага	тоо	383	200	73	180	377

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ЗХЗХ

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.4.** Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

№ 25 (80)	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>	
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.4.1-р арга хэмжээ</b> Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	
	<i>Төлөөлөлтийн</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.1.

		уялдаа:					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
		Шаардагдах хөрөнгө	10,000.0 мянган төгрөг				
		Хариуцах нэгж	ЗХЗХ				
		Суурь түвшин	-				
		Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөө батлах, хэрэгжилтийн хувь				
		Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> - Төлөвлөгөө боловсруулан батлах; - Хэрэгжилтийг 50 хувь хангах; - Ижил төстэй 2 байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох.  <b>Жилийн эцэст:</b> Төлөвлөгөөний хэрэгжилт 100%.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/, Азийн сан, Азийн хөгжлийн банк, Оросын Холбооны Улсын Төрийн өмчийг удирдах холбооны агентлаг зэрэг байгууллагуудтай холбоо тогтоох чиглэлээр ажилласан. Энэхүү ажлын хүрээнд дараах байгууллагуудтай харилцан хамтын ажиллагааны зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагатай /OECD/ хамтран Филиппин улсын Манила хотод 2019 оны 9 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалын Азийн сүлжээ”-ний 12 дахь удаагийн хурал, 2019 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Парис хотноо зохион байгуулсан “Төрийн өмчлөл ба хувьчлалын туршлага” Ажлын Хэсгийн 33 дахь удаагийн уулзалтад тус тус илтгэл тавин, амжилттай оролцсон.</li> <li>Азийн сан ТББ, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай “Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах” гурвалсан гэрээг 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр байгуулан ажиллав. Гэрээний хүрээнд хамтын ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөнд тусгасан дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулан Хууль зүйн яаманд хүргүүлэх, төрийн өмчит 10 хуулийн этгээдэд (“Шивээ овоо” ХК, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК, Монголын Төмөр Зам” ТӨХК, “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Монголын Цахилгаан Холбоо” ХК, “Дулааны цахилгаан станц 4” ТӨХК, “МИАТ” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Төв АЗЗА” ТӨХК, “Дархан АЗЗА” ТӨХК) компанийн засаглалын үнэлгээ хийж, үнэлгээний тайланг компани тус бүр дээр гарган холбогдох зөвлөмжүүдийг өгөх, компанийн засаглалын ахисан түвшний сургалт зохион байгуулах зэрэг ажлыг талууд хамтран хийж гүйцэтгэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын болон төрийн өмчит компаниудын 500 гаруй албан хаагчдыг компанийн засаглалын ахисан түвшний сургалтад хамруулж, гэрчилгээ олгох ажлыг хийсэн.</li> <li>2020 онд Азийн хөгжлийн банктай хамтран “Монгол Улсад хэрэгжүүлэх техникийн туслалцааны төсөл”-ийн хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцон “Төрийн өмчит хуулийн этгээдийн төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр хүний нөөцийг чадавхижуулах хөтөлбөр” сэдэвт төслийг англи, монгол хэл дээр боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн.</li> <li>Оросын Холбооны Улсын Төрийн өмчийг удирдах холбооны агентлагаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл ирүүлсэн бөгөөд санамж бичгийг байгуулах бэлтгэлийг хангаж байна.</li> </ol>					
		Зарцуулсан хөрөнгө	10,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
		Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/, Азийн сан, Азийн хөгжлийн банк, Оросын Холбооны Улсын Төрийн өмчийг удирдах холбооны агентлаг зэрэг байгууллагуудтай холбоо тогтоох хүчин чармайлт гаргаж, хамтын ажиллагааны эхлэл тавигдсан.				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100 %, “Бүрэн хэрэгжсэн”					

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.4.-ийн үр дүн:** Гадаад харилцаа, хамтын ажиллагаанд ахиц өөрчлөлт гарсан байна.

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			2018 он	Эхний хагас жил		Жилийн эцэс	
				Төл	Гүй	Төл	Гүй
1.	Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.4.1. Хамтын ажиллагаа тогтоосон	тоо	-	-	-	2	2

	байгууллага						
2.	<b>Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.4.1.</b> Туршлага судлах арга хэмжээнд оролцсон байдал	тоо	-	-	-	2	2

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ЗХЗХ

### НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ № 3. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

**Гүйцэтгэлийн зорилт №3.2.5.** Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх

№ 26 (81)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.5.1-р арга хэмжээ</b>					
	Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах					
	Төлөвлөлтийн уялдаа:	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.1, Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	2,500.0 мянган төгрөг				
	Хариуцах нэгж	ЗХЗХ				
	Суурь түвшин	-				
	Шалгуур үзүүлэлт	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хэрэглэгддэг журам, дүрмийг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д нийцүүлэх.				
	Хүрэх түвшин	<p><b>Эхний хагас жилд:</b> Журмуудын төслийг шинэчлэн боловсруулсан байна: Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”;</li> <li>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”;</li> <li>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм”;</li> <li>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Журмуудын төсөлд албан хаагчаас санал авч тусган хууль зүйд нийцүүлэн боловсруулж, шинэчлэн батлуулсан байна;</li> <li>- Хэрэгжилтийн хувь: 90-100%.</li> </ul>				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан <a href="https://www.able.mn">https://www.able.mn</a> дотоод сүлжээнд байршуулан, албан хаагчаас санал авч, газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдүүлэв.</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-д 3 заалт шинээр нэмж, 47 заалтад найруулгын өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулсан бөгөөд хэлтэс, албаны дарга, ахлах мэргэжилтэн нарт танилцуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-т 1 заалт шинээр нэмж, 51 заалтад найруулгын өөрчлөлт оруулах төслийг боловсруулан албан хаагчид, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлд танилцуулсан бөгөөд албажуулахаар хүлээгдэж байна.</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг боловсруулах ажил хийгдээгүй байна.</p>				
	Зарцуулсан хөрөнгө	2,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	Хүрсэн түвшин	<b>Жилийн эцэст:</b> Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх 1 журмыг шинэчлэн мөрдүүлж, 2 журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан, 1 дүрмийг боловсруулах ажил хийгдээгүй байна.				
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		70%, “Хэрэгжих шатанд”				

№ 27 (82)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.5.2-р арга хэмжээ</b>					
	Шинээр батлагдах, шинэчлэн найруулах, өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журмын төсөл,					

нэр, дугаар	санал боловсруулах					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.4.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	2,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Чанарын үзүүлэлт: - ТӨБЗГ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын төсөл боловсруулах, санал өгөх; - Бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал өгсөн байдал.				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ТӨБЗГ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын төсөл боловсруулах арга хэмжээ зохион байгуулах;</li> <li>- Бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал өгсөн байна.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ТӨБЗГ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын төсөл боловсруулах арга хэмжээ зохион байгуулагдаж, батлагдсан байх;</li> <li>- Бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал өгсөн байна.</li> </ul>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/100, А/101, А/102, А/103 дугаар тушаалаар “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”, “Дуудлагын худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 128 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 260, 268, 269, 271, 400 дугаар тогтоолоор тус тус баталж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Мөн Сангийн яамнаас боловсруулсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-ын төсөлд 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А-1/245, “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын төсөлд 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А-1/1290 дугаар албан бичгээр тус тус санал хүргүүлсэн.</p>				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	2,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв				
	<i>Хүрсэн түвшин</i>	<p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийн бүртгэл, зохицуулалтын асуудлаар нийт 5 журмыг шинэчлэн боловсруулж, боловсронгуй болгох, батлуулах, мөрдүүлэх арга хэмжээ авсан.</li> <li>- “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”, “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын төсөлд тусгах санал боловсруулан Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.</li> </ul>				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100 %, “Бүрэн хэрэгжсэн”				

№ 28 (83)	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.5.3-р арга хэмжээ</b>					
	Хууль, шүүхийн байгууллагад үүссэн хэрэг, маргаанд байгууллагыг төлөөлж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар 4.4.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	6,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	2019 оны төлөвлөгөө батлагдах үед хууль, хяналтын байгууллагад хянан шийдвэрлэх ажиллагааг явагдаж байгаа хэрэг, маргаан, 2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэрэг маргааны ТӨБЗГ-ын талд шийдвэрлэгдсэн хувь 100%				

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хууль, хяналтын байгууллагад хянан шийдвэрлэх ажиллагааг явагдаж байгаа хэрэг, маргааны тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэрэг маргааны ТӨБЗГ-ын эрх ашиг хангагдаж шийдвэрлэгдсэн хувь
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэрэг, маргааныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхэд холбогдох албан хаагчдын уялдаа холбоог хангаж, хамтран ажиллах;</li> <li>- Хэрэг, маргааны талаар судалж, санал боловсруулах, удирдлагын түвшинд хэлэлцэж, шийдвэрлэх арга хэмжээ авах;</li> <li>- Хуулийн хүрээнд хэрэг, маргааныг шийдвэрлүүлсэн байх;</li> <li>- Хэрэг, маргааны шийдвэрлэлтийн талаар дүгнэлт, тайлан боловсруулж, тайлагнах, тухай бүр;</li> <li>- Хэрэг, маргаан шинээр гаргахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн хүрээнд шийдвэрлүүлсэн байна;</li> <li>- Хэрэгжилтийн хувь – 70-100%.</li> </ul>
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	<i>Хэрэгжилт</i>	<p>Тайлант хугацаанд, шүүхэд худалдан авах ажиллагаатай холбоотой 7, өмчтэй холбоотой 17, томилгоотой холбоотой 4, бусад асуудлаар 3, нийт 31 хэрэг маргаан хянагдаж байгаагаас захиргааны 11, иргэний 16, эрүүгийн 3, арбитрын 1 хэрэг байна. Дээрх хэрэг маргааныг хууль, шүүхийн байгууллагад хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгч оролцсон. Тайлант хугацаанд, нэхэмжлэлээ татан авсан 4, эвлэрсэн 3, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж 1, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 2, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 1, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 1, нэхэмжлэлийг шүүхээс буцаасан 2, нийт 14 хэрэг маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн. Эцэслэгдэн шийдвэрлэгдсэн 14 хэрэг маргааны 11-г нь ТӨБЗГ-ын эрх ашгийг хангаж, 3 нь бусдын эрх ашгийг хангасан байна.</p> <p>Одоогоор шүүхэд худалдан авах ажиллагаатай холбоотой 1, өмчтэй холбоотой 12, томилгоотой холбоотой 3, бусад асуудлаар 1 нийт 14 хэрэг, маргаан хянагдах ажиллагаа үргэлжилж байна. Эдгээрт захиргааны 5, иргэний 9, эрүүгийн 2, арбитрын 1 хэрэг байна. ТӨБЗГ нь хянагдаж байгаа нийт 14 хэргийн 4-т нэхэмжлэгчээр, 10-т хариуцагчаар оролцож байгаа ба хэргийн явцын талаарх мэдээллийг цаг тухай бүр удирдлагуудад мэдээлэн, сар, улирал, жилийн тайлан мэдээнд тусгуулан ажилласан.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	6,500.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны төсөв
	<i>Хүрсэн түвшин</i>	<b>Жилийн эцэст:</b> Тайлант хугацаанд шүүхэд нийт 31 хэрэг маргаан хянагдаж, 14 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн. Тэдгээрийн 11-д ТӨБЗГ-ын эрх ашгийг хангасан шийдвэр гарсан байна.
<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>		100%, “Бүрэн хэрэгжсэн”

<b>№ 29 (84)</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.5.4-р арга хэмжээ</b>					
	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэнтэй холбоотой шинэчлэн батлагдсан журам, зааврыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Стратеги төлөвлөгөөний зорилтын 4.4.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	2,500.0 мянган төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	ЗХЗХ				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчийн тоо;</li> <li>- Чанарын үзүүлэлтээр хэмжинэ: Хэрэгжилтийн хувь – 70-100%.</li> </ul>				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн хүрээнд шинээр батлагдан гарах дүрэм, журам, зааврын судалгаа хийх;</li> <li>- Холбогдох байгууллагуудтай хамтран албан хаагчдыг сургалтад хамруулах.</li> </ul> <p><b>Жилийн эцэст:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Батлагдан гарсан дүрэм журамд нийцүүлэн газрын дотоод дүрэм журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг хангах;</li> <li>- 3 сургалт, давхардсан тоогоор 100 албан хаагч;</li> <li>- Нийт албан хаагчдад сургалт зохион байгуулж, мэдлэг мэргэшлийг нь дээшлүүлсэн байх.</li> </ul>				



